



ТӨРИЙН ӨМЧИЙН БОДЛОГО, ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ТОГТООЛ

2021 оны 06 сарын 15 өдөр

Дугаар 221

Улаанбаатар хот

Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 1, 2, 66 дугаар зүйлийн 3 дахь хэсгийг тус тус үндэслэн “Дулааны хоёрдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн 2018 он, 2019 оны санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар нийт 272.4 сая төгрөгийн зөрчил дутагдал илэрснийг тэмдэглээд ТОГТООХ нь:

1.“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн санхүү, эдийн засгийн үйл ажиллагаанд хийсэн баримтын шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг арилгах арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар баталсугай.

2.“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” төрийн өмчит хувьцаат компанийн Төлөөлөн удирдах зөвлөл болон гүйцэтгэх захирал Ц.Минжинхүүд санхүүгийн сахилга батыг хэвшүүлэн дотоод хяналтыг сайжруулж, дор дурдсан арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг үүрэг болгосугай:

2.1.Шалгалтын мөрөөр авах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулан хэрэгжилтийг ханган ажиллах;

2.2.Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэгт заасны дагуу батлагдсан зорилтот түвшингийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй үл хөдлөх болон үндсэн хөрөнгөд хамаарах хөдлөх хөрөнгө худалдан авахгүй байх;

2.3. Худалдан авах ажиллагаанд “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль”, Сангийн сайдын 2017 оны 363 дугаар тушаалаар баталсан “Худалдан авах ажиллагааг төлөвлөх, тайлагнах журам”-ыг мөрдөн ажиллах;

2.4.Цаашид үйлдвэрийн газрын орлого, ашигт ажиллагааг дэмжих ач холбогдолгүй, ойн арга хэмжээний хандивын орлого, зарлагын гүйлгээг байгууллагын дансаар хийхийг таслан зогсоох, түүнтэй холбогдуулан зорилтот түвшинд төлөвлөөгүй өглөг үүсгэх нөхцөл бүрдүүлэхгүй байх;

2.5.Станцын өргөтгөл шинэчлэлтэд шаардлагатай хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг шийдвэрлүүлэх болон ашиглалтгүй байгаа Шингэн шилний үйлдвэрийг цаашид хэрхэн ашиглах талаар санал боловсруулан эрх бүхий байгууллагад хүргүүлж шийдвэрлэх зохион байгуулалтын арга хэмжээ авч ажиллах;

132001460

\Huraldaanii material\2021 он\2021.06.15 10-r hūraldaan.docx

2.6. Тогтоолын биелэлтийг 2021 оны 3 дугаар улиралд багтаан Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газарт ирүүлэх.


3. Энэхүү тогтоолын биелэлтэд хяналт тавьж ажиллахыг Төрийн өмчийн хяналт шалгалтын хэлтэс (Ц.Түвшинзаяа)-т даалгасугай.

ДАРГА

Б.ЦЭНГЭЛ

ТӨРИЙН ӨМЧИЙН ХЯНАЛТ
ШАЛГАЛТЫН ХЭЛТСИЙН ДАРГА

Ц.ТҮВШИНЗАЯА



 Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын
 2021 оны 06 дугаар сарын 25-ны өдрийн
 26 дугаар тогтоолын хавсралт

**“Дулааны хоёрдугаар цахилгаан станц” төрийн өмчтэй хувьцаат компанийд
хийсэн шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлыг
арилгах арга хэмжээний жагсаалт**

Д/д	Шалгалтаар илэрсэн зөрчил, дутагдлын утга	Хамрах хугацаа	Үнийн дүн /сая төгрөг/	Зөрчигдсэн эрхзүйн акт	Цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний санал
1	Хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд тусгагдаагүй зөвшөөрөлгүй хөрөнгө бэлтгэсэн	2018-2019	74.3	Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 8 дахь хэсэг, ТӨБЗГ-ын 2017 оны 659, 2019 оны 14, 245 дугаар тогтоол	ТБОНӨ-ийн тухай хуулийн хэрэгжилт, эрх бүхий байгууллагаас баталсан төлөвлөгөөг мөрдөж ажиллах.
2	Худалдан авах ажиллагааны төлөвлөгөөнд тусгагаагүй шууд худалдан авалт хийсэн.	2018	17.3	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах хуулийн 48 дугаар	ТБОНӨ-ийн тухай хуулийн хэрэгжилт, эрх бүхий байгууллагаас баталсан төлөвлөгөөг мөрдөн ажиллах.
3	Нээлттэй тендер шалгаруулалтын журмыг хэрэглэхээс зайлсхийсэн	2018-2019	180.8	Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах хуулийн 8 дугаар зүйл	Нийт төсөвт өргтийг хувааж хэд хэдэн тендер шалгаруулалт явуулахыг хориглох
ДҮН			272.4		